



МОНГОЛ УЛСЫН
САНГИЙН САЙДЫН ТУШААЛ

2015 оны 12 сарын 10 өдөр

Дугаар 380

Улаанбаатар хот

Г

Г

Тушаалд нэмэлт, өөрчлөлт
оруулах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 47 дугаар зүйлийн 9 дэх хэсэг, 52 дугаар зүйлийн 52.1.3 дахь заалтыг үндэслэн ТУШААХ нь:

Нэг. Сангиин сайдын 2014 оны 212 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан “Үнэлгээний хорооны зохион байгуулалт, үйл ажиллагаа, урамшууллыг зохицуулах журам”-ын хавсралтаар батлагдсан “Үнэлгээний хорооны гишүүнээр ажиллахыг зөвшөөрсөн мэдүүлэг”-ийг өөрчлөлт оруулан 1 дүгээр хавсралтаар баталсугай.

Хоёр. Сангиин сайдын 2014 оны 212 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан “Үнэлгээний хорооны зохион байгуулалт, үйл ажиллагаа, урамшууллыг зохицуулах журам”-ын 6 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт “холбогдох маягт, тооцоо, бусад үндэслэлүүдийг” гэснийг “холбогдох маягт, тооцоо, бүрэн бөглөсөн энэхүү журмын 2 дугаар хавсралт тендер шалгаруулалтын бүртгэлийн хуудас, бусад үндэслэлүүдийг” гэж өөрчилсүгэй.

Гурав: Сангиин сайдын 2014 оны 212 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан “Үнэлгээний хорооны зохион байгуулалт, үйл ажиллагаа, урамшууллыг зохицуулах журам”-ын 2 дугаар хавсралт болгож “Тендер шалгаруулалтын бүртгэлийн хуудас”-ыг нэмэлтээр 2 дугаар хавсралтаар баталсугай.

Дөрөв: Энэхүү журмын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн нарийн бичгийн дарга /Х.Ганцогт/, Хууль, худалдан авах ажиллагааны бодлогын газар /Э.Хангай/-т тус тус даалгасугай.

САЙД

Б.БОЛОР



000806

Сангийн сайдын 2015 оны 12 дугаар сарын 101-ны өдрийн
330 тушаал 1 дүгээр хавсралт

ҮНЭЛГЭЭНИЙ ХОРООНЫ ГИШҮҮНЭЭР АЖИЛЛАХЫГ
ЗӨВШӨӨРСӨН МЭДҮҮЛЭГ

(Үнэлгээний хороонд томилогдсон гишүүдэд хамаарна)

..... би
(ҮХ-ны гишүүний нэр, албан тушаал)

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46.1.1, 46.2, 47.1-т заасны дагуу үнэлгээний хорооны бүрэлдэхүүнд гишүүнээр томилогдон ажиллахыг зөвшөөрч, энэ мэдэгдлээр дараах баталгааг гаргаж байна:

НЭГ.

- Би тухайн тендер шалгаруулалтад оролцогч талуудтай сонирхлын зөрчилгүй, хэрэв сонирхлын зөрчил бий болох нөхцөл үүссэн тохиолдолд шударгаар мэдэгдэж, үнэлгээний хорооны гишүүнээс татгалзана;
- Тендерт оролцогч нь хээл хахууль санал болгох, дарамт шахалт үзүүлэх зэргээр тендер шалгаруулалтын дүнд нөлөөлөхийг оролдвол энэ тухай захиалагч болон хууль хяналтын байгууллагад нэн даруй мэдэгдэх.
- Үнэлгээний хорооны үйл ажиллагаанд хувийн сонирхолоор бус, хөндлөнгийн байр сууринаас хандана;
- Үнэлгээний хорооны гишүүнээр томилогдсоноос хойш, үнэлгээ хийх явцад энэ мэдэгдлийн 1.1-1.2-т дурдсан нөхцөл байдал үүсвэл Захиалагчид нэн даруй мэдэгдэнэ.
- Үнэлгээний хорооны хуралдаанд хүндэтгэх шалтгаангүйгээр оролцохоос татгалзахгүй.

ХОЁР.

- Тендерийн баримт бичиг боловсруулах, тендерийн үнэлгээ хийх ажиллагааг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, тогтоомж болон Сангийн сайдын 2012 оны 301 дүгээр тушаалаар батлагдсан “Үнэлгээний хорооны зохион байгуулалт, үйл ажиллагааг зохицуулах журам”, Сангийн сайдын 2012 оны 194 дүгээр тушаалаар батлагдсан “Тендерийн үнэлгээний заавар”-т заагдсан эрх, үүргийн дагуу шуурхай, шударга хийж гүйцэтгэнэ.

Гарын үсэг: _____

Огноо: _____

Албан ажлын хэрэгцээнд:

	Овог, нэр	Албан тушаал	Гарын үсэг	Огноо	Цаг, минут
Хүлээн авсан					
Хүлээлгэн өгсөн					

Сангийн сайдын 2015 оны 12
дугаар сарын 10.....ны өдрийн
330 тушаал 2 дугаар хавсралт

ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН
БҮРТГЭЛИЙН ХУУДАС

№	Үйл ажиллагаа	Тийм	Үгүй
Тендер шалгаруулалтыг зарлан мэдээлэхээс өмнө			
1.	Үнэлгээний хороонд орж ажиллах гишүүдээр мэдүүлэг бөглүүлсэн эсэх		
2.	Үнэлгээний хорооны гишүүд худалдан авах ажиллагааны чиглэлээр мэргэшсэн эсэх /гэрчилгээний дугаар/		
3.	Үнэлгээний хороонд хөндлөнгийн төлөөллөөс орж ажилласан эсэх /гишүүдийн нэрс, гэрчилгээний дугаар/		
4.	Батлагдсан нийт төсөвт өртгийг үндэслэл болгосон эсэх		
5.	Холбогдох зураг төсөв, техникийн тодорхойлолт болон шаардлагатай мэдээлэл эрх бүхий байгууллагаас батлагдаж ирсэн эсэх		
Гэрээ байгуулахаас өмнө			
6.	Гүйцэтгэлийн баталгаа ирүүлсэн эсэх батлагдсан төсөвт багтсан эсэх		
7.	Гэрээ хуульд заасан стандартын дагуу хийгдсэн эсэх		